

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 821 д^үгээр дамжааны суралцагч,
дэд хурандаа Б.Баярх^ү

**ХИЛ ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ БЭЛЭН
БАЙДЛЫН ОНОЛЫН Ү НДЭС**

Хураангуй. Энх^ү илтгэлээр хил хамгаалалтын албаны бэлэн байдлын онолын Үндэс, т^үний хууль, эрх з^үйн зохицуулалтын орчинг судлахыг зорилоо.

Т^үлх^үр 2. Улсын хил хамгаалалт, албаны бэлэн байдал, хил хамгаалах байгууллага, сургалт, онол, байлдааны зарчим.

Аливаа цэргийн анги, салбарын бэлэн байдал нь Үргэлж сайжирч боловсронгуй болж тайван цагт ч энэ чанараа хадгалж байдаг. Цагийн байдал эрс хурцадсан болон дайны байдалд байлдааны ажиллагаа давамгайлах шинжтэй болдог. Хил хамгаалах байгууллагын байнгын бэлэн байдлыг товчоор “Алба-байлдааны байнгын бэлэн байдал” гэсэн нэр томъёо, агуулгаар илэрхийлж болох Үндэстэй гэж судлаачийн хувьд Үзэж байна. Хил хамгаалах салбарын алба-байлдааны байнгын бэлэн байдал гэдэг нь цагийн байдлын ямар ч н^үхц^үл, бэрхшээлтэй цаг Үед хилийн тухай хуулиар оногдуулсан чиг Үүрэг, т^үнд нийц^үлэн Үг^үгдс^үн зорилт, Үүрэг тушаалыг цаг хугацаанд нь багтаан амжилттай биел^үлэх чадвар¹” гэж тодорхойлсон байдаг.

Албаны бэлэн байдал гэдэг нь Улсын хил хамгаалах Үүргийг зохион байгуулалттайгаар тогтоосон хугацаанд амжилттай биел^үлэх чадварыг тодорхойлсон хилийн анги, салбар, удирдлагын нэгжийн бэлэн байдал² гэж тодорхойлжээ.

Цэргийн урлагийн зарчмууд нь зэвсэгт тэмцлийн дотоод агуулга, шинж т^үл^үв, з^үй тогтолыг бодиттойгоор илэрхийлж байдаг учраас захирагч, штаб Үүссэн цагийн байдалд баримжаалах, зэвсэг, техникийг хэрэглэх хамгийн оновчтой аргыг олоход туслаж, дайсны тоогоор бус чадвараар бут цохих бололцоог бий болгож байдаг учраас анги, салбар дийлдэш^үй х^ү ч чадалтай амьдрах чадвартай байдаг.

Дайны онол нь байлдааны бэлтгэл сургалтыг з^үв баримжааллыг боловсруулж, тодорхойлох б^үг^үд цэргийн юунд, яаж сургах, тэдгээр нь

¹ Ш.Арвай. Монгол Улсын хил хамгаалах салбарын алба байлдааны бэлэн байдал. - УБ., 2010. 27 хуудас.

² М.Ганболд. Хилийн нэр томъёоны тайлбар толь. - УБ., 2010.

ямар шалгуурт бэлэн байх, орчин үеийн байлдааны тактик, зэвсгийг сайн эзэмшсэн байх, болзошгүй дайсан, түүний хэцтэй болон сул талыг мэддэг, байлдааны шинэ хэрэгслэлтэй тэмцэж, тэдгээрээс хамгаалж чаддаг болгоход сургана гэсэн нь бэлэн байдлыг хангахад гол зүйл цэргийн хэргийн сургалт юм.

Байлдааны бэлэн байдлыг оператив-тактикийн түвшинд нэгтгэл, анги, салбарууд цагийн байдлын ямар ч нөхцөлд тогтоосон хугацаанд тулалдаан /байлдаан/-д зохион байгуулалттайгаар орж, тавьсан байлдааны цэргийг биелүүлэх чадвар гэж ойлгоно. Байлдааны байнгын бэлэн байдлын ач холбогдлыг онол, практик талаас нь авч үзвэл:

Онолын хувьд зэвсэгт тэмцлийн хөгжилтийн нөлөөлөл, дайн, зэвсэгт мөргөлдөөн, байлдааны шинж чанар тэдгээрийг явуулах аргуудын нээл баримтлалын өөрчлөлтөөр "байлдааны байнгын бэлэн байдлын агуулга" тодорхойлогдоно.

Практикийн хувьд байлдаанд байнга бэлэн байх зарчим нь тэрэмгийллийг няцаахад техник, зэвсэглэл, цэрэг бэлэн байх.

Байлдааны өндөр бэлэн байдлыг анги, салбарт байлдаанд биеэр, ур чадвараар, оюуны чадавхиар бэлэн байснаар хангана.

Биеэр бэлэн байх нь зэвсэг, байлдааны техник байлдаанд хэрэглэхэд бэлтгэгдэж, сум, галт хэрэгсэл, материал хэрэгслийн нөөцөөр хангагдсан, бие бүрэлдэхүүн байлдааны ажиллагааг нэн даруй явуулах бэлтгэлтэй байх нөхцөл.

Ур чадвараар бэлэн байх нь анги, салбарт байлдааны чадавхийн итгэлцээр 0.6-аас доошгүй байж, бие бүрэлдэхүүн эзэмшсэн зэвсгээрээ дайсныг 0.5-аас багагүй магадлалтайгаар устгах, техник тоног хэрэгслэлээ гацаа шалтгаангүй ажиллуулах дадлагатай болсон байх байдал юм.

Дээр дурьдсан цэргийн хэргийн урлагийн онол, байлдааны зарчимтай албаны бэлэн байдал гэсэн ойлголт нь цэргийн анги, нэгтгэлийн үйл ажиллагааны голлох чиглэл болохыг ойлгуулж байна.

Хил хамгаалалтын албаны бэлэн байдал. Хил хамгаалах байгууллагын чиг цэргийнхээ хэрэгдэл одоо мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн акт, дүрэм, журам, зааварт хэрхэн тодорхойлогдож, тусгагдсан талаар судлахад Монгол Улсын төрийн цэргийн бодлого, Аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хилийн талаар баримтлах бодлого, Хилийн тухай хууль зэрэгт зааснаар Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд болон хилийн цэргийн анги, салбарууд гадны зэвсэгт тэрэмгийллийг няцаахад алба-байлдааны бэлэн байдалд байх шаардлагатай юм.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын Үндэс баримт бичгийн 2.1. дэх заалтад “Батлан хамгаалах үйл ажиллагаа нь Үндэсний аюулгүй

байдлыг хангах Үйл ажиллагааны бэрхдэлхүүн хэсэг бүгд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн” 7.1. дэх заалтад “Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ. Дайны байдлын үед хилийн цэрэг. онцгой байдлын байгууллага нь зэвсэгт хүчний бүтцэд бүрэг гүйцэтгэнэ”, 7.3 дахь заалтад “Тайван цагт хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь бие даасан бүрэг гүйцэтгэх бүгд тэдгээрийн бүтэц, чиг үүргийг хуулиар тогтооно¹ “гэж тус тус заасан нь улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг юм.

Монгол Улсын Хилийн тухай хуулинд “Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хилийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн бүс, зурваст улсын хил хамгаалах байгууллагаас улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, цэргийн, инженер-техникийн, улс төр, дипломатын, эдийн засгийн, тагнуулын зэрэг арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг **улсын хил хамгаалалт** гэнэ гэж тодорхойлжээ.

Хилийн алба нь хилийн асуудлаар байгуулсан Монгол Улс, олон улсын гэрээ, Хилийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн, улсын хилийг тодорхой байлгах, хилийн зөрчлийг илрүүлэн, таслан зогсоох замаар улсын хилийн халдашгүй дархан байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хил хамгаалах байгууллагаас явуулж буй зохион байгуулалттай Үйл ажиллагаа юм.

Албаны бэлэн байдлын зэрэг гэдэг нь албаны бэлэн байдлыг зохион байгуулж, удирдах баримт бичгээр тогтоосон тодорхой хугацаанд улсын хил хамгаалах бүрэг биелүүлэхэд бэлэн болох хилийн анги, салбар, удирдлагын нэгжийн байдал юм. Хилийн цагийн байдалтай уялдуулан тогтоох бүгд анги, салбарууд нэг зэргээс нэг зэрэгт шууд буюу дэс дараалан шилжиж болно.

Албаны бэлэн байдлын тухай төхөн талаасаа улс орны тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн

¹ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. -УБ., 2015.

² Монгол Улсын Хилийн тухай хууль. 2002.

халдашгүй дархан байдал. ард түмний язгуур эрх ашгийг хангахад чиглэгдсэн хэдий ч дайн. байлдаан, зэвсэгт тэмцлийн хөгжлийн нөлөөлөл, шинж чанар, тэдгээрийг явуулах аргуудын эзэл баримтлалын өөрчлөлт, эл тогтол талаас судалж түүнээс хамгаалах, байлдах арга тактикийг боловсруулан дайн байлдаанд бэлтгэхэд систем, бүтэц зохион байгуулалт, удирдлага. сургалт хүмүүжил, зэсвэг техник, хангалт, нөөцүүдийг бий болгож бэхжүүлэхэд онол талаас нь судалж байжээ. Иймд хилийн цэрэг үндсэн чиг үүргийнхээ дагуу улсын хилийн аюулгүй байдлыг хангахад дэлхий дахин, хүрш орнуудын нөхцөл байдлыг судалж гадны халдлагаас хамгаалах, тавигдсан үүргийг амжилттай биелүүлэхэд бэлтгэгдсэн байх тул бэлэн байдлын тогтолцоог бүх талаас нь судлах шаардлагатай гэж үзэж байна. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах нь хилийн цэргийн анги, салбаруудын үүрэг бүгд улсын хил дээр албаны бэлэн байдлыг хангах нь захирагч, удирдлагын үндсэн үүрэг болох нь нотлогдож байна. Иймд анги, салбарын удирдлага албаны бэлэн байдлыг хангахад үнэмлэхүй бодит байдалд ухаалгаар хандаж, шинжлэх ухааны үндэслэлтэй үйл ажиллагааг явуулах бүгд бүх шатны удирдлагууд бие бүрэлдэхүүний сургалтыг чанаржуулах, зэвсэглэл техникийг чадварлаг эзэмшихэд дадлагажуулах, нөөц, цувраажилтийг бүрдүүлж, орчин үеийн удирдахуйн ухаанд тулгуурлан удирдах нь зайлашгүй юм.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 821-р дамжааны суралцагч,
дэд хурандаа Б.Эрдэнэбат*

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТЫГ БИЙ БОЛГОХ АСУУДАЛ

Хураангуй. Энэхүү илтгэлдээ хил хамгаалах байгууллагын хяналт шалгалтын тогтолцоонд эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлж үйл ажиллагааны хяналтыг боловсронгуй болгох асуудлыг хндэс тавихыг зорилоо.

Түлхүүр үг. Хил хамгаалах байгууллага, эрсдэл, эрсдэлийн удирдлага, эрсдэлд суурилсан хяналт шалгалт.

Аливаа байгууллага нийгмийн, хүрээлэн буй орчны, технологийн, аюулгүй байдал, хамгаалалтын, санхүүгийн засгийн талаар тавьсан зорилтдоо хүрэх үйл явцыг тодорхой бус болгодог дотоод, гадаад хүчин зүйл, төлөвлөлтэй тулгарч байдаг.

Байгууллагын Үйл ажиллагааны энэхүү тодорхой бус байдлын Үр дагаврыг “эрсдэл” гэж Үздэг ба байгууллагын бҮхий л Үйл ажиллагаа эрсдэлийг дагуулдаг ажээ.

Орчин Үед байгууллагууд Үүрийн онцлог, чадамжид нийцүүлэн зохих хэмжээнд эрсдэлээ удирдаж байгаа боловч эрсдэлийн удирдлагыг илүү Үр нөлөөтэй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарсаар байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний хувьд эрсдэлийн удирдлагын Үүрийн гэсэн онцлог хэв шинжтэй Үйл ажиллагааг цэргийн албаны хүрээнд зохион байгуулж ирсэн бөгөөд энэ нь цэргийн дүрэм, цэргийн албаны удирдлагын баримт бичгүүд болон байлдааны дүрэм, зааварт тусгалаа олсон байдаг. Тухайлбал, цэргийн албыг анги, салбарын байлдааны бэлэн байдал, дүрмээр тогтоосон дэг журам, сахилгыг чанд сахиулах, зэвсэг техник, эд аж ахуйг найдвартай хамгаалах, цэргийн алба хаагчдын Үдүр тутмын амьдрал, Үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангахад чиглэгдэн дээд штабын заавар, анги, нэгтгэлийн штабын төлөвлөлт, захирагчийн шийдвэрээр батлагдан хэрэгжиж байдаг эрсдэлийн удирдлагын хэв маяг агуулсан тогтолцоо гэж болно.

АНУ-ын зэвсэгт хүчин дэх эрсдэлийн удирдлагыг “PM 5-19 Composite risk menejment” баримт бичгээр зохицуулдаг бөгөөд цэргийн анги, салбарын ажиллагааны төлөвлөлтөд “Risk assessment matrix буюу эрсдэлийн Үнэлгээний матриц”-ийг боловсруулан хэрэглэдэг байна.

Хил хамгаалах байгууллагын тухайд “Үүрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 6.4. дэх хэсэгт заасныг Үндэслэн “Аж ахуйн нэгж, байгууллагын Үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний Үдрийн 311 дүгээр тогтоолоор баталжээ. Уг тогтоолын 1.5. дэх хэсэгт заасан “Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуй нэгж Үүрээр баталж мөрднө.” гэсэн заалтыг Үндэслэн хэрэгжүүлж байна.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд хяналт шалгалтыг явуулахдаа эрсдэлд суурилсан байдлаар сонголт хийн явуулах шаардлага урган гарч байна. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг явуулахын тулд байгууллагын хэмжээнд эрсдэлийн Үнэлгээ хийж, Үүсэж болох эрсдэлээ тодорхойлж тогтоох нь чухал юм.

Судалгаагаар хил хамгаалах байгууллагад дараах эрсдэл гарч болзошгүй байдал харагдаж байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны эрсдэл

1. Албаны амьтадтай харьцах Үийн эрсдэл
2. Инженерийн байгууламж ашиглах Үийн эрсдэл
3. Ажлын байрны аюулгүй байдал алдагдах
4. Хүнсний аюулгүй байдал
5. Техниктэй харьцах Үийн Үйлдвэрлэлийн осол
6. Гэнэтийн осол, гэмтэл, Үвчл Үлийн Үед гарах эрсдэл

2. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл

1. Хүний нийцлийн бодлого алдагдах
2. Удирдлага зохион байгуулалт доголдох
3. Нийцлийн буюу эрх зүйн, зохицуулалтын эрсдэл
4. Албан хаагч авлигад Үртх

3. Гадаад хүчин зүйлсийн эрсдэл

1. Тал хээрийн болон ойн түймэр
2. Байгалийн голомтот гоц халдварт Үвчин гарах
3. Хүн, малын халдварт Үвчин гарах
4. Үерийн аюул, Үер, усанд осолдох
5. Цасан ба шороон шуурганд түүрх, осгох
6. Хориотой болон хязгаарлсан эд зүйл нэвтрүүлэх

4. Дотоод хүчин зүйлсийн эрсдэл

1. Хилийн манаанаас зэвсэг буруу хэрэглэх
2. Зэвсэг, галт хэрэглэл алдагдах, Үрэгдэх
3. Байгууллагын болон албаны нууц задрах, алдагдах
4. Мэдээ мэдээлэл тасалдах, хоцрох

Иймд хил хамгаалах байгууллага, хилийн анги, салбар нь эдгээр эрсдэлд дүн шинжилгээ хийж, сонголт хийн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийх нь цаг хугацаа, хүрэнг мөнг хэмнэн гарч болох зүрчил дутагдал, аливаа учралаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Эрсдэлд суурилсан тогтолцооны үр нөлөө нь:

> Гуравдагч талын мэдээллийг авч, үнэн бодит мэдээллийн сантай тулгаж шалгах;

> Эрсдлийн шинжилгээнд үндэслэн хяналт шалгалтыг хийх;

> Ажлын тайланг стандартчилах;

> Удирдлагын шийдвэр гаргах, бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх хангалттай, цаг үеэ олсон мэдээллээр хангах автоматчилагдсан тогтолцоогоор дамжин хэрэглэгддэг бүгд түүнээс шалтгаалдаг.

Эрсдэлд суурилсан удирдлагын тогтолцоо нь Хил хамгаалах байгууллагад нийцлийг хуваарилах, гүйцэтгэлийг удирдахад нь туслах юм.

Амжилттай хэрэгжсэн эрсдэлд суурилсан тогтолцоо нь мөн цэцэглэж, хөгжлийн саад бэрхшээлийг арилгахад дэмжлэг үзүүлж, салбар дах хууль журмыг дагаж мөрдөхд учирч буй саад бэрхшээлийг буруулдаг.

Эрсдэлд суурилсан тогтолцоог хэрэгжүүлэхэд техникийн, улс төрийн болон институцийн олон асуудлууд тулгардаг байна. Чухамдаа, эрсдлийн удирдлагыг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэрэгсэл болгон ашиглах нь эрсдлийг тодорхойлох, эрсдлийн дүн шинжилгээ хийх, нэлэх, анхаарал хандуулах хэсгийг тодорхойлох, эцэст нь эрсдлийг засах, дахин нэлэх зэргийг багтаасан үйл явц юм.

Индэр эрсдэлтэй анги, салбаруудад чиглэсэн сонголтот хяналт шалгалтын стратегийг үргэжлүүлэх хэрэгжүүлсэнээр байгууллагад зорилтоо хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын стратегийг амжилттай хэрэгжүүлэх гол цэг нь хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хяналт шалгалт хийх объектийг сонгох үйл ажиллагааг тусад нь авч үзэх шаардлагатай юм.

*ХСИС-ийн Хууль сахиулах удирдлагын
академийн 821 дүгээр дамжааны суралцагч,
хошууч Б.Мырзабек*

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,

ТӨНДӨН ЛӨЛӨХ ХОЧИН ЗӨЙЛ

Хураангуй. Аюулгүй байдлыг олон талаар нь судлаж байсан бөгөөд сүүлийн үед аюулгүй байдлыг хангахад хүн нэг бүрийн аюулгүй байдал чухал гэж үзлэг ба байгууллагын аюулгүй байдлыг ямар нэгэн байдлаар судалсан судалгаа нэн ховор байна.

Төлхөөр г. Аюулгүй байдал, байгууллагын аюулгүй байдал, байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл.

Аюулгүй байдал гэж юу вэ? Зорилго, судалгаа аль эсвэл үүр зүйлийг хэлэх үү? Аюулгүй байдал гэдэг нь судалгааны төвшинд хамааран харилцан адилгүй бөгөөтэй учраас нарийн тодорхойлоход бэрх. Ихэнхи судлаачид аюулгүй байдал гэдгийг түрэмгийлэлээс ангид байхаар хязгаарлаж ойлгодог. Германы судлаач Ричард Лоевэнтал уг нийтлэг ойлголт дээр нийгэм, улс төрийн хараат бус байдлыг хамруулсан бол Жозеф Най эдийн засгийн чиглэлийн нэмжээ.

Харин Ричард Уллман аюулгүй байдлыг дан ганц цэргийн аюул заналаар хязгаарлах нь бодит байдалтай нийцэхгүй гэж үзсэн. Тэрээр “Ард иргэдийн амьдралын төвшинг богино хугацаанд бууруулах аюултай нөхцөл байдал үүсэх, эсвэл төрийн болон төрийн бус байгууллагын